

## Материалимпэкс ХК-ийн 2022 оны эхний хагас жилийн Үйл ажиллагааны тайлан

### Агуулга

- Компанийн түүхэн замнал
- Эрхэм зорилго, зорилт
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн товч танилцуулга
- Хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ
- Хараат бус аудиторын тайлан

### ТҮҮХЭН ЗАМНАЛ

Монгол Улсад үйлдвэр, орон сууц, нийтийн аж ахуй, хөдөө аж ахуйн барилга байгууламж барьж байгуулах ажлыг цаашид эрчимтэй хөгжүүлэх тапаар нам, засгаас тавьсан зорилтыг хэрэгжүүлэх, ЗХУ болон социалист бусад орноос зээл тусламжаар болон худалдааны шугамаар авч байсан, түүнчлэн дотоодын үйлдвэрүүдээс гаргаж байсан материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг хүлээн авах, хадгалах, хэрэглэгч байгууллагуудад нийлүүлэх ажлыг эрхлэн гүйцэтгэх байгууллагыг МАХН-ын I өв хорооны Улс төрийн товчооны 1957 оны 3-р сарын 28-ны 108-р тогтоолоор Гадаад худалдааны яамны харьяанд Техник туслалцааны бааз нэртэйгээр байгуулсан нь одоогийн “Материалимпэкс” ХК юм.

Техник туслалцааны бааз нь эхний үед ГХЯ-ны харьяа Бөөний худалдааны баазтай нэг дор ажиллаж байгаад удалгүй хангамжийн болон хэрэглэгч байгууллагуудын ажлын уялдааг сайжруулах үүднээс Сайд нарын Зөвлөл 1958 оны 8-р сарын 10-ны өдрийн 46-р тогтоолоор Улсын барилгын хорооны харьяанд шилжүүлжээ. Тус бааз байгуулагдахдаа 508,000 төгрөгийн үндсэн, 4.5 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй, цехэд–10, санхүүгийн–9, үндсэн ба туслах ажилчин–170 байв.

Материалимпэкс ХК нь өдгөө гадаад дотоод худалдаа, барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл, улс хоорондын тээвэр зуучлал, аялал жуулчлал, ажлын байрны түрээс, агуулахын аж ахуй гэсэн үндсэн чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын шилдэг 100 аж ахуйн нэгжээр удаа дараа шалгарсан томоохон компаниудын нэг болон өргөжлөө.

## КОМПАНИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Манай компанийн эрхэм зорилго нь үйлчлүүлэгчдийн найдвартай түнш байж, өөрийн үйл ажиллагааг өргөжүүлэх замаар улс эх орон, нийслэл хотын нийгэм эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулан, улмаар ажиллагсдынхаа бодит орлогыг нэмэгдүүлж, ажлын байр шинээр бий болгох, компанийн хөрөнгө санхүүгийн тогтвортой байдлыг бий болгоход оршино.

Бидний зорилт - барилгын болон хүнсний салбарт гадаадын үйлдвэрлэгчдийг дотооддоо холбох түүчээ болох, Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, Сайн засаглалыг хэрэгжүүлэгч, үлгэр жишээ хувьцаат компани болох

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. ТУЗ-ийн дарга – Дагвын Оюун. 1973 онд төрсөн, эмэгтэй. Дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй.
2. ТУЗ-ийн ердийн гишүүд:
  - 2.1 Баярын Зориг. 1953 онд төрсөн, эрэгтэй. Дээд боловсролтой, барилгын инженер мэргэжилтэй. Монгол улсын Зөвлөх инженер
  - 2.2 Базарсадын Батбаатар. 1977 онд төрсөн, эрэгтэй. Дээд боловсролтой, зураач, ХАБЭА-ч мэргэжилтэй.
  - 2.3 Боролдойн Болортуяа. 1978 онд төрсөн, эрэгтэй. Дээд боловсролтой, гадаад харилцааны менежер, орчуулагч мэргэжилтэй.
  - 2.4 Пүрэвцэрэнгийн Баатарцэрэн. 1986 онд төрсөн, эрэгтэй. Дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй.
  - 2.5 Дагвын Төмөр-Очир. 1964 онд төрсөн, эрэгтэй. Тусгай дунд боловсролтой, барилгын дотоод дизайнер мэргэжилтэй.
3. Хараат бус гишүүд:
  - 3.1 Цагааны Ариунаа. 1971 онд төрсөн, эмэгтэй. Дээд боловсролтой, багш мэргэжилтэй.
  - 3.2 Бямбажавын Саранцэцэг. 1973 онд төрсөн, эмэгтэй. Дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй.
  - 3.3 Чойсүрэнгийн Энхтуул. 1979 онд төрсөн, эмэгтэй. Дээд боловсролтой, сэтгүүлч мэргэжилтэй.



## Хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ

Тус компани тайлант хугацаанд гүйцэтгэх захирлын шууд удирдлага дор 2 алба, 5 хэлтэс, 4 нэгжтэйгээр үйл ажиллагаа явууллаа.

Захиргаа, үйлчилгээний хэлтсийн чиг үүрэг нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй хангах зорилгын хүрээнд хэлтэс, нэгжийн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөг нэгтгэх, Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнах, ажиллагсдаа мэргэшүүлэх, байгууллагын ил тод байдлыг ханган ажиллах, хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх, төсөв хөрөнгийг төлөвлөн, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, ажиллагсдын ажил үүрэгт нь тохирсон бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалин хөлсний зохицуулалт хийх, төрийн болон хувийн хэвшлийн гадна дотны байгууллагуудтай харьцах, удирдлагын баримт бичиг, гэрээ хэлцэлүүд, захирлын тушаал боловсруулж, тэдгээрийн хэрэгжилт, биелэлтэд хяналт тавих ажиллагааг гүйцэтгэхээс гадна компанийн дотоод үйлчилгээ, цэвэрлэгээ, харуул хамгаалалтын ажлыг хариуцах, архив, албан хэрэг хөтлөлтийг хууль, журмын дагуу явуулах зэрэг ажил үүргийг өдөр тутамдаа хэрэгжүүлдэг.

“Материалимпэкс” ХК нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 84 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явууллаа.

Компанийн Удирдах ажилтны “Шуурхай зөвлөгөөн”-ийг 5 удаа хийж, компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг харъяалсан хэлтэс нэгжийн удирдлага, гүйцэтгэх удирдлагатай зөвшилцөн явуулж байна.

Байгууллагын дотоод удирдлагын системийн “Хүний нөөцийн удирдлага, цаг бүртгэлийн удирдлага”-ын “ZKTeco Attendance Management” программыг албан хэрэгцээнд ашиглан, Хүний нөөцийн дэд программд компанийн нийт ажилтан, албан хаагчдыг бүртгэлжүүлж, албан тушаалд шинээр томилогдсон болон, ажлаас чөлөөлөгдсөн ажилтан, албан хаагчдын бүртгэл мэдээллийн өөрчлөлтийг тухай бүр хийж, баяжилтийн нэгдсэн бааз үүсгэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд 28 албан бичиг хүлээн авч холбогдох хэлтэс, нэгжид танилцуулан, 8 албан бичигт дурдсан хугацаанд нь хариуг хүргүүлсэн. Төрийн байгууллага, албан тушаалтан, харилцагч аж ахуйн нэгж, иргэдэд хандаж нийт 218 албан бичиг илгээжээ.

Худалдах худалдан авах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, түрээсийн, даатгалын зэрэг 10 гаруй төрлийн 52 гэрээг байгууллага, хувь хүнтэй хийсэн байна.

Албан тушаалын сул орон тоонд тухайн ажлын байранд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг зааж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд нээлттэй зар түгээж, ил тод, багаар сонгон шалгаруулан ажил, албан тушаалд томилж, сул орон тоог нөхөх ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулсан. Тайлант хугацаанд захирлын 44 тушаал гарсан.



Ажиллагсдынхаа ажлын идэвх санаачлагыг сайжруулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2019 оны 07 дугаар сараас хэрэгжүүлсэн урамшуулалт цалин хөлсийг үргэлжүүлэн олгож байгаа бөгөөд он гарснаас хойш нийт ажиллагсдын үндсэн болон хийснээр олгох цалин хөлсний хэмжээг 2 удаа өөрчлөн, орон тоо, цалин хөлсний хэмжээг нэмэгдүүллээ.

#### Барилгын материалын худалдааны талаар

Тайлант хугацаанд нийт 26,783,001,128 төгрөгийн борлуулалт хийснээс 1,221,525,210 төгрөгийг шинэ 13 харилцагчидад борлуулалт хийж чадсан байна.

Арматур 2180 тоннын борлуулалт хийжээ.

#### Бетон зуурмаг

Эхний хагас жилд Сошиаль /facebook/ орчинд өдөр бүр зарыг 2-3 удаагийн давтамжтайгаар текст болон зургийг боловсруулан зар оруулсан. Зарын дагуу 44 дуудлага орж ирсэнээс 2 дуудлага ажил болж, 21 дуудлага нь гадны болон дотоод хүчин зүйлс нөлөөлж ажил болж чадаагүй. Энэхүү орж ирсэн дуудлага борлуулалт нь зөвхөн интернэт орчинд Facebook зарын груп ашиглан хийгдсэн. Мөн барилгын төслүүдээр явсан ажилаас Жигүүр гранд ХХК-тай 202м3 буюу 44,440,000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.

#### Орон сууц

"My town" хөрөнгийн төслийн орон сууцыг худалдан авагчдад үзүүлэн танилцуулах ажлаа үргэлжлүүлэн хийж 23 орон сууцыг худалдан борлуулсан байна. Байрны засвар үйлчилгээтэй холбоотой ажлуудыг хөрөнгө оруулагч талын ажилтнуудтай хамтран шийдвэрлэж орон сууцыг худалдан авагч талд хүлээлгэн өгч байна.

D2 болон 108, 113 дугаар байрнуудын дулаан зогсоолоос 18 дулаан зогсоол худалдан борлуулж эд хөрөнгийн эрхийн бүртгэлд шаардагдах холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн худалдан авагч талд хүлээлгэн өгсөн.

2022 оны 4,5 дугаар саруудад "МИШЭЭЛ ЭКСПО ЦЕНТР"-д зохион байгуулагдсан орон сууц, амины орон сууц, барилгын материалын үзэсгэлэн худалдааг хэлтсийн ажилчдын хамт үзэж танилцан шинээр ашиглалтанд орох орон сууц болон амины орон сууцны төслүүдийн үнэ, байршлын мэдээллүүдийг цуглуулан нэгтгэлээ. Төсөл хэрэгжүүлэгч болон гүйцэтгэгч барилга угсралтын компаниудын холбогдох хаягийг цуглуулан 40 гаруй компани, хувь хүнд арматур, бетон зуурмаг, вакум цонхны үнийн санал имэйлээр илгээсэн байна.

#### Олон улсын тээвэр зуучлалын талаар

##### Импортын тээвэрлэлт

Тус компани нь 2022 оны эхний хагас жилд нийт 435 чингэлэг, задгай ачааны тээвэр 6-г зохион байгуулсан нь өмнөх оны хагас жилтэй харьцуулбал нийт чингэлэг тээвэр 41%-иар буурсан үзүүлэлттэй харагдаж байна. Зуучилсан чингэлэгийн хувьд урьд оны хагас жилтэй харьцуулбал төлөвлөгөө 50%-тай биелсэн байна.



Энэ оны хагас жилийн хугацаанд тээвэр зуучлалаар хүлээн авсан чингэлэг ба бусад ачааны тухай дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтэнд харуулав.

Манай компанийн зуучлалаар тээвэрлэсэн чингэлэг болон вагонтой ачаа барааны 74 %-ийг шинэ ба хуучин машин, автомашины сэлбэг, 21 %-ийг хүнсний бүтээгдэхүүн, үлдсэн 5%-ийг гэр ахуйн бараа, тавилга ба барилгын материал гэх зэрэг бараа эзэлж байна. Урьд оны хагас жилтэй харьцуулбал хуучин ба шинэ машины тээвэрлэлт 45%, хүнсний барааны тээвэрлэлт 52%-иар буурсан үзүүлэлттэй байна.

### Вагоны тээвэрлэлт

2022 оны эхний хагас жилд нийт 509 вагон тээвэрлэсэн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хүснэгтэнд харуулав.

Талбайн хэмжээнд ирсэн вагон	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Нийт
Материалимпэкс	76	147	152	39	53	42							509

Өнгөрсөн оны хагас жилд хүлээж авсан вагоны тоотой харьцуулж үзвэл 18 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Вагоны тээврийн гол ачаа нь цагаан будаа, гоймон, давс, ургамлын тос, элсэн чихэр, варенье, бүх төрлийн чихэр, печенье, овъёс, малын тэжээл, хивэг, барилгын материал, ундаа зэрэг болно.

### Гаалийн Хяналтын Бүс

2022 оны хагас жилд Материалимпэкс ХК-ийн Гаалийн Хяналтын талбайгаар нийт хүлээж авсан чингэлэгийн тоог доорх хүснэгтээс үзнэ үү:

Талбайн хэмжээнд ирсэн ачаа	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Нийт
Чингэлэг тоо	185	160	291	442	568	906							2552

Өнгөрсөн оны хагас жилд талбайн хэмжээнд хүлээж авсан чингэлэгийн тоотой харьцуулбал 18 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар

Улсын онцгой комиссын 2021 оны 01 албан даалгавар, Гаалийн Ерөнхий газрын 2021 оны 01 албан даалгаврын хүрээнд гаалийн хяналтын бүс болон албан байр, ерөө тасалгаа, хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, бичиг баримтад мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйтгэл хийлгэх, ажилчдын эрүүл мэнд, ариутгал халдваргүйтгэлийн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын дэглэмийг бүх түвшинд чандлан сахих, амны хаалтгүй хүнийг нэвтрүүлэхгүй байх, гаалийн хяналтын бүсэд ажиллаж буй гааль, мх, гаалийн зуучлагч, банк, тээврийн ажилтан, үйлчлүүлэгч нарт



халдвар хамгааллын дэглэм сахиулах шаардлага тавьж, үйлчлүүлэгч иргэн бүрийн биеийн халууныг хэмжиж, гарыг ариутгуулан асуумж бөглүүлж, хүний бөөгнөрөл үүсгэхгүй хүн хоорондын зай бариулан, бага багаар нэвтрүүлж байлаа.

Сургалтын "МКЛ" төвтэй хамтран тусгай мэрэгжилийн үнэмлэхтэй ажиллагсадын дүрмийн мэдлэгийн давтан сургалт, ариутгалын "БатАриусгал" ХХК-тай хамтран COVID-19 халдварын үед оффисын барилга, ажилчдын байр, харуулын байр, агуулах зэрэг байгууламжуудад заагдсан хугацаа бүрд ариутгал хийх, 03 дугаар сард ОБЕГ-ын Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвтэй хамтран нийт ажиллагсдыг 100% хамруулан сургалт зохион байгуулах, байгуулага орчны их цэвэрлэгээг хийх, эмийн сангуудын нөхөн хангалтыг цаг тухай бүрд хийх, ажиллагсадын нормын хувцас хэрэглэлийн чанарыг сайжруулах, ажилчидад 3 шатны зааварчилгыг өгч, үүссэн нөхцөл байдалд тохируулан зааварчилга, заавар, чиг үүрэг өгч ажиллаж байна.

Тайлант хугацаанд НӨАТ-ын тайлан, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг сар бүр, ААНОАТ-ын тайлан, ХХОАТ-ын тайланг улирал тутам, санхүү байдлын дэлгэрэнгүй тайлан буюу баланс, Тээврийн хэрэгслийн албан татварын тайлан, үл хөдлөх эд хөрөнгийн татварын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, хуулийн хугацаанд нь зохих байгууллагад тушааж иржээ.

Компанийн ажлын ар тал болох техник, машин механизм, барилга, дулаан, уур ус, цахилгаан хангамжийн бэлэн байдлыг ханган ажилладаг Үйлдвэр техникийн хэлтсийн хамт олон цахилгаан, дулаан, барилга, яндан хоолой, сантехник, машин механизмын онцгой сааталгүй байгаа нь үйлдвэр үйлчилгээний ажлыг цаг хугацаанд нь хийж, гүйцэтгэх таатай нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна. Мөн өргөн тээвэрлэх үйлчилгээ үзүүлдэг гүүрэн крануудын гэрэлтүүлгийг бүрэн шинэчилж аюулгүй ажиллагааг хангаж засвар үйлчилгээг тогтмол хийж крануудад бүрэн магадлагааг хийлгэсэн байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар компанийн хэмжээнд хулгай, гэмт хэргийн ямар нэгэн зөрчилгүй ажилласан нь харуул хамгаалалт сайн байсны илрэл болно. Нийтийг хамарсан цар тахлын үед байгуулагад ямар нэгэн өвчний голомтгүй ажилласан нь цэвэрлэгээ үйлчилгээ ариутгалыг өндөр түвшинд хийж гүйцэтгэсэнтэй холбоотой гэж үзэж байна.

Мөн эхний хагас жилийн байдлаар санхүүгийн хувьд ашигтай ажилласан нь санхүү байдлын тайлангаас харагдаж байгаа бөгөөд энэ нь төрөөс импортын хүнсний бараанд НӨАТ-аас чөлөөлсөн, цахилгаан дулааны үнэ тарифт хөнгөлөлт үзүүлсэн зэрэг нь нөлөөлсөн. Бид цаашид борлуулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч томоохон хэмжээний төсөл хөтөлбөрөө үргэлжлүүлэх, үйлчилгээний төвийн барилгын ажлыг дуусгах, орон сууцны хорооллын төслийн В4 барилгын ажлыг эхлүүлж, ажиллагсдын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулж ажиллана.



**"МАТЕРИАЛИМПЭКС" ХК**